

**Үндэсний хүний хөгжлийн илтгэлийг танилцуулах арга
хэмжээнд Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын
Сайд С.Эрдэнийн хэлсэн үг**

**2016 оны 6 дугаар сарын 14
10.00 цаг, НҮБ-ын байр**

Хатагтай Биата Транкман,
Эрхэм хүндэт Хатагтай, Ноёд Та бүхний энэ өдрийн амгаланг эрье.

Үндэсний хүний хөгжлийн илтгэлийг залуучуудын асуудлаар боловсруулан гаргаж байгаа нь өнөөгийн нөхцөл байдал, дэлхийн улс орны чиг хандлагатай нийцсэн, цаг үеэ олсон бодлогын баримт бичиг бий болж байгаад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, эрдэмтэн судлаачид, төр ба иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгч Та бүхэнд юуны өмнө талархал илэрхийлье.

Залуучууд гэдэг бол аль ч улсад нийгмийн хөгжил, эдийн засгийн хөдөлгөгч гол хүч, тухайн улс орны нүүр царай, ирээдүй болж байдаг билээ. Тэр тусмаа залуучуудын орон гэгдэх Монгол Улсын хувьд өсвөр үе, залуучуудын нийгмийн хөгжилд оруулах хувь нэмэр, оролцоо санаачилгыг хөхиүлэн дэмжих асуудал нь төрийн бодлогын төвд байх ёстой юм.

Энэ ч утгаараа Монгол Улсын Засгийн газрын зүгээс олон талт цогц арга хэмжээг авч хэрэгжүүлээд байгаа бөгөөд цаашид хэрэгжүүлэх зорилго, зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Засгийн газраас Залуучуудын асуудал хариуцсан төрийн бүтцийг бий болгож, төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж, оролцоог нэмэгдүүлэн, залуучуудад чиглэсэн бүхий л үйл ажиллагаанд хамтран ажиллаж байна. Мөн төрийн бүтцэд салбар дундын уялдааг хангах, үндэсний хэмжээнд бодлого боловсруулан хэрэгжүүлэх Засгийн газрын Үндэсний хороо, орон нутагт салбар дундын уялдаа, бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах салбар хороог бүх аймаг, дүүрэгт байгуулан ажиллаж байгаа юм.

Залуучуудын оролцоог бүх түвшинд хангах үндсэн зарчмыг баримтлан залуучуудын оролцоотойгоор тэдний тулгамдсан асуудлыг тодорхойлох хүрээнд үндэсний чуулган, аймаг, бүсийн хэлэлцүүлэг, салбар дундын уулзалтыг үе шаттайгаар зохион байгуулж, төрийн шат шатны байгууллагуудад залуучуудын хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, зөвлөмж, уриалгыг тунхаглаж, түүнийг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллалаа.

Залуучуудын өмнө тулгамдсан тулгуур асуудлууд болох эрүүл мэндийн асуудал, чанартай боловсрол, ажилгүйдэл, тэгш бус оролцоо, эрх хамгаалал зэрэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор олон улсын түвшинд баримталж буй бодлого, хөтөлбөр, чиг хандлагатай уялдуулан төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага болон залуучуудын оролцоотойгоор Монгол Улсын төрөөс залуучуудын хөгжлийн талаар баримтлах бодлого, "Монгол залуу хүн" Үндэсний хөтөлбөрийг боловсруулан Засгийн газарт өргөн барихад бэлэн болоод байна.

Түүнчлэн, залуучууд бол нийгмийн халамж хүртэгч бус бүтээн байгуулагч, шинийг санаачлагч гэдэг утгаараа залуучуудыг хөгжүүлэх, ухамсар хандлагыг нэмэгдүүлэх, бие даан амьдрах чадвар

олж авахад нь дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах цогц арга хэмжээ бүхий "Залуучуудын хөгжил хөтөлбөр" төслийн эхний үе шатыг 11 аймаг, 3 дүүрэгт амжилттай хэрэгжүүлж байна.

Ингэснээр залуучуудад чиглэсэн нэгдсэн бодлого, түүнийг хэрэгжүүлэх салбар дундын бүтэц бүх шатанд бий болж, нөгөө талаас залуу хүн бүрийг идэвхижүүлэх, бие даан амьдрах чадвар бүхий залуучуудтай орон болох зорилттой цогц арга хэмжээг хэрэгжүүлэхийг чармайн ажиллаж байна.

Бид энэхүү зорилтод хүрэхэд хүний хөгжил, тэр дундаа залуучуудын хөгжлийн асуудлыг нарийвчлан судалж, Монгол Улсын болоод олон улсын түвшинд баримталж буй бодлого арга хэмжээг харьцуулан, манай орны залуучуудын онцлог хэрэгцээнд нийцүүлэн боловсруулсан дүгнэлт, зөвлөмж нь Монгол Улсын Засгийн газар болоод Монголын залуу хүн бүрт үнэтэй хувь оруулж байгаад талархалтай байна.

Мөн Үндэсний хүний хөгжлийн илтгэлийг боловсруулахад хүчин чармайлт, нүр их хөдөлмөр, хичээл зүтгэл гаргасан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамт олон, үндэсний хөтөлбөр боловсруулахад оролцсон удирдах болон зөвлөлдөх хорооны гишүүд, эрдэмтэн судлаачид та бүхэнд дахин талархал илэрхийлье.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.
